

ᠮᠣᠩᠭᠡᠯᠠᠯᠠᠢ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ  
ᠲᠦᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠤᠳᠢᠲᠤ ᠬᠠᠵᠠᠷ  
“ᠣᠷᠤᠨ ᠨᠤᠲᠬᠢᠶᠢᠨ 2026 ᠣᠨᠤ ᠲᠦᠰᠦᠢᠶᠢᠨ  
ᠲᠦᠰᠦᠢᠶᠢᠨ ᠲᠦᠰᠦᠯᠳᠦ ᠳᠦᠭᠨᠡᠯᠲᠦ ᠡᠭᠦᠬᠡ”



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗАР

“ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН  
ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ”

2025 оны 11 дүгээр сар



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/35

Алтай хот

Нийцлийн аудитын тайланг  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Эрх шилжүүлэх тухай” А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.1, 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт гаргах" нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймаг, сумдын Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

3. Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмж, шийдвэрийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасан хугацаанд, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймаг, сумдын Засаг дарга нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 30 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (Д.Цэрэнханд)-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Эрдэнэчимэг)-т даалгасугай.



Г.ГҮНЖИДМАА



## АГУУЛГА

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ .....	4
НЭГ. ТАТВАРЫН БОЛОН ТАТВАРЫН БУС ОРЛОГЫГ 1,770.0 СЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ БАЙНА. ....	6
ХОЁР. ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ, ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ ЗӨРЧСӨН 3,270.4 СЯ ТӨГРӨГИЙН УРСГАЛ ТӨСВИЙН ЗАРДЛЫГ ХАСАХ САНАЛТАЙ БАЙНА.....	10
ГУРАВ. ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА. ....	14
ДҮГНЭЛТ:.....	17
ЗӨВЛӨМЖ:.....	18



### Товчилсон үгийн жагсаалт

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗЗНДНТУТ	Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХБГ	Хүлээгдэж буй гүйцэтгэл
УИХ	Улсын Их Хурал
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар

### Дүрслэл, хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Аймгийн 2026 оны төсвийн төслийн харьцуулсан судалгаа	5
Дүрслэл 2	Аймгийн 2026 оны орон нутгийн орлогын төсөл	6
Дүрслэл 3	Малын тоо, малд ногдуулах албан татварын орлогын гүйцэтгэл	7
Дүрслэл 4	Засаг дарга ерөнхий дансны зарцуулалтын судалгаа	11
Дүрслэл 5	Инноваци судалгаа бизнес хөгжлийн төвийн санхүүжилт	13
Дүрслэл 6	Аймгийн хүн амын шилжих хөдөлгөөн	15
Дүрслэл 7	ОНХС-ийн санхүүжилт, гүйцэтгэл	15
Хүснэгт 1	Усны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	9
Хүснэгт 2	Төсвийн зарлагын хязгаар, харьцуулсан судалгаа	10
Хүснэгт 3	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө	14
Хүснэгт 4	ОНХС-гийн төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ	16

### Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг нэмэгдүүлэх санал	6
Хавсралт 2	Газрын төлбөрийн орлогыг нэмэгдүүлэх санал	8
Хавсралт 3	Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогыг нэмэгдүүлэх санал	9
Хавсралт 4	Торгуулийн орлогыг нэмэгдүүлэх санал	9
Хавсралт 5	Төсөвт байгууллагын өөрийн орлогыг нэмэгдүүлэх санал	9
Хавсралт 6	Аймгийн хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөнд тусгаагүй хөрөнгө оруулалтын ажлын жагсаалт	15
Хавсралт 7	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17



	<b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</b>
<b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</b>	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд “Аудитын сэдэв батлах тухай” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны А/ 107 дугаар тушаал, Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэн хийж гүйцэтгэлээ.
<b>Аудитын зорилго</b>	Аймгийн Засаг даргын өргөн мэдүүлсэн Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглүүлсэн эсэхийг үнэлэх, төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд дүгнэлт, зөвлөмж гаргахад аудитын зорилт чиглэсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"><li>➤ Төсвийн орлогыг тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж, орлого нэмэгдүүлэх боломжтой эсэх;</li><li>➤ Төсвийн төсөлд тусгасан зарлагыг бууруулах боломжтой эсэх;</li><li>➤ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хуульд заасан тусгай шаардлага, шалгуурт нийцүүлэн төлөвлөсөн эсэх;</li></ul>
<b>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</b>	Аудитыг АДБОУС, Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”, 2022 оны А/67 дугаар “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал” гарын авлагыг ашиглаж гүйцэтгэсэн.
	Аудитаар Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050 үзэл баримтлал, Алсын хараа-2050, Шинэ сэргэлтийн бодлого, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгасан холбогдох бодлогын зорилттой уялдсан эсэхэд нэгтгэсэн дүн шинжилгээ, харьцуулалт хийх, тулган баталгаажуулах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг аудитын горимыг хэрэгжүүлэн ажиллаж хөтөлбөр, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
<b>Аудитын хамарсан хүрээ</b>	Аудитад аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Татварын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Байгаль орчны газар болон холбогдох бусад байгууллагын аудитын сэдэвт хамаарал бүхий үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ.



**Талуудын хүлээх үүрэг, хариуцлага** Засаг даргаас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэхэд аудит хийж, Төсвийн тухай хуульд заасан хугацаанд дүгнэлт гаргах нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

**Аудитын бүрэлдэхүүн, хугацаа** Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа удирдан зохион байгуулж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг чанарын хяналт тавьж, стандартыг хангуулан, ахлах аудитор Д.Цэрэнханд ахалж, ахлах аудитор М.Атарцэцэг, аудитор Н.Гэрэлмаа, Э.Сүнжидмаа, Б.Цэвэлмаа, Б.Мөнхболд, Г.Булган нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр баталсан байна.

Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2026 оны төсвийн хязгаарыг баталжээ.

Тус тогтоолоор аймгийн нийт төсвийг 77,756.5 сая төгрөгөөр, суурь орлогыг 40,812.6 сая төгрөгөөр, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 10,240.1 сая төгрөгөөр, суурь зарлагыг 51,052.6 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Баталсан төсвийн хязгаарт нийцүүлэн 2026 оны төсвийн төслийг боловсруулахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгосон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны төсвийн төсөлд орлогыг 24,190.1 сая төгрөгөөр, урсгал зарлагыг 70,920.2 сая төгрөгөөр тооцож Сангийн яаманд 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдөр хүргүүлсэн байна.

Сангийн яамнаас 2025 оны төсвийн орлогыг 24,190.1 сая төгрөгөөр, урсгал зардлыг 55,810.3 сая төгрөгөөр хянасан байна.

Монгол Улсын 2026 оны Төсвийн тухай хуулиар ирэх оны төсвийн жилд Говь-Алтай аймгийн орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг 13,181.7 сая төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 19,801.8 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталжээ.

Төсвийн орлогын 26,059.9 сая төгрөг буюу 63.0 хувийг сумдын төсөвт, 15,452.8 сая төгрөг буюу 37.0 хувийг аймгийн төсөвт төвлөрүүлэхээр тооцсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны урсгал зардлыг 54,694.2 сая төгрөг буюу Сангийн яамны хянасан дүнгээс 1,116.1 сая төгрөгөөр илүү төлөвлөсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд орон нутгийн 45 төсвийн байгууллага 766 орон тоотой ажиллан, 41,512.7 сая төгрөгийн төсвийн орлогыг бүрдүүлж, үндсэн тэнцлийн алдагдал 13,181.7 сая төгрөгийг улсын төсвөөс дэмжлэгээр авч, тусгай



сангаас 130.0 сая төгрөг, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн эргэн төлөлтөөс 496.9 сая төгрөг зарцуулан, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, авто замын сангийн шилжих үлдэгдлээс 724.7 сая төгрөг, ОНХС-гийн орлогын шилжүүлгээр 19,801.8 сая төгрөг, ОНХС-ийн шилжих үлдэгдлээс 1,350.4 сая төгрөг нийт 77,198.2 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн зарцуулахаар төсөвлөсөн байна.

Дүрслэл 1. Аймгийн 2026 оны төсвийн төслийн харьцуулсан судалгаа (сая төгрөг)



Эх сурвалж: [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn), аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс

Өмнөх онтой харьцуулахад суурь зардал 14,910.8 сая төгрөг буюу 22.4 хувиар, төсвийн дэмжлэг 16,503.5 сая төгрөг буюу 56.0 хувиар, ОНХС-ийн орлогын шилжүүлэг 5,188.4 сая төгрөг буюу 20.8 хувиар, нийт зардал 21,956.5 сая төгрөг буюу 22.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Засгийн газраас 2026 оны төсвийн жилд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр байна. Үүнд:

- Төрийн албан хаагчдын тоог 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 9.0 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлэх,
- Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолын дагуу орон нутагт төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах зорилгоор 2024 оноос олгож эхэлсэн орон нутгийн нэмэгдлийн хувь хэмжээ болон хамрах хүрээг нэмэгдүүлэх,
- Улсын төсвийн дэмжлэг буурсантай холбоотой тогтмол зардлыг 20.0 хувиар, багаж техник хэрэгслийг худалдан авах зардлыг 100.0 хувиар бууруулсан.

Орон нутгийн төсвийн төсөлд аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр 2026 онд 5 хөтөлбөр, арга хэмжээний 31 төсөл, арга хэмжээг 8,154.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр, сумдын ОНХС-д 12,997.9 сая төгрөгийн шилжүүлгийг олгохоор төлөвлөсөн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд шилжих 1 төсөл, арга хэмжээг 185.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Авто замын сангаас 2026 онд шилжих 4 төсөл, арга хэмжээг 538.9 сая төгрөгөөр, шинээр 4 төсөл, арга хэмжээг 587.1 сая төгрөгөөр, нийт 1,126.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төсөвлөсөн байна.



Орон нутгийн 2026 оны төсвийн төсөл боловсруулахдаа Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 7 дугаар зүйлд заасан 2 шаардлагыг хангаагүй байна. Үүнд:

- Хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх;
- Худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргасан байх.


Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны төсвийн төсөл нь Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1<sup>1</sup>,31.3<sup>2</sup>-31.4<sup>3</sup>-д заасан зарчим, тооцоо судалгаанд үндэслэсэн,баримт материал иж бүрэн байх шаардлагуудыг хангахгүй байна.

### НЭГ. ТАТВАРЫН БОЛОН ТАТВАРЫН БУС ОРЛОГЫГ 1,770.0 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ БАЙНА.

1.1 Сангийн яамнаас 2025 оны татварын орлогыг 26,848.6 сая төгрөгөөр хянасныг төсвийн төсөлд 39,774.9 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 1,383.7 сая төгрөгөөр хянасныг төсвийн төсөлд 1,737.8 сая төгрөгөөр, нийт 41,512.7 сая төгрөгөөр тооцож төлөвлөсөн байна.

1.2 Орон нутгийн төсвийн төсөлд 2026 оны орлогыг 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 1,335.4 сая төгрөгөөр бууруулан тооцсон байна. Энэ нь малын тоо толгойд ногдуулах албан татварыг огт төлөвлөөгүйтэй холбоотой байна.

Дүрслэл 2. Аймгийн 2026 оны орон нутгийн орлогын төсөл (сая төгрөг)



Эх сурвалж: Аймгийн Засаг даргаас өргөн барьсан 2026 оны төсвийн төсөл

1.3 Төсвийн орлогын дийлэнх буюу 43.0 хувийг Есөнбулаг сумын, 37.0 хувийг аймгийн төсвийн орлого бүрдүүлж байна. Есөнбулаг сумын төсвөөс 12,212.0 сая төгрөгийн орлогыг аймгийн төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.

### Татварын орлого

1.4 Хувь хүний орлогын албан татварын орлогыг 2025 оны тодотгосон төсвөөс 396.3 сая төгрөгөөр бууруулан, 23,973.4 сая төгрөгөөр төлөвлөсөн нь хөрөнгийн орлогыг хасаж тооцсонтой холбоотой байна.

<sup>1</sup> Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн төсөл дараах шаардлагыг хангасан байна:

<sup>2</sup> жилийн төсвийн хязгаарт багтаасан байх;

<sup>3</sup> Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд дараах тооцоог хавсаргана




1.5 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг цалингийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлээгүй байна. Тухайлбал: Боловсролын салбарын ажилчдын цалинг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 6.0 хувиар нэмэгдүүлэн тооцоход татвар **800.0** сая төгрөгөөр нэмэгдэх боломжтой байна. (Дэлгэрэнгүйг хавсралт №-1-аас үзнэ үү)

1.6 **Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын** дахин хуваарилалтын орлогыг 2025 оны батлагдсан төсвөөс 2,885.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 11,985.0 сая төгрөгөөр Сангийн яамнаас ирүүлсэн тоо мэдээлэлд үндэслэн тооцсон байна.

1.7 **Хөрөнгийн татварыг** 2025 оны тодотгосон төсвөөс 1,396.3 сая төгрөгөөр бууруулан, 1,118.3 сая төгрөгөөр төлөвлөсөн нь малын тоо толгойд ногдуулах албан татварын орлогыг огт төлөвлөөгүйтэй холбоотой. Энэ нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1<sup>4</sup>, 5.2<sup>5</sup> дахь заалттай нийцэхгүй байна.

Дүрслэл 3. Малын тоо, малын тоо толгойд ногдуулах албан татварын орлогын гүйцэтгэл (мянган толгой, сая төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл /2021-2024 он/

1.8 Аймгийн хэмжээнд малын тоо толгойд ногдуулсан албан татвар жил бүр өсөлттэй байна. Сангийн яамнаас малын тоо толгойд ногдуулах албан татварын орлогыг хянаагүй шалтгаанаар 2026 оны төсвийн төсөлд огт төлөвлөөгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2<sup>6</sup>, 23 дугаар зүйлийн 23.2<sup>7</sup>-т заасантай нийцэхгүй байна.

1.9 Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлж, орон нутагт төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэн, татварыг ногдуулж бүрэн төвлөрүүлэх шаардлагатай байна.

1.10 Малын тоо толгойд ногдуулах албан татварыг Татварын газрын мэдээлэлд үндэслэн **409.2** сая төгрөгөөр тооцож, төлөвлөхөөр байна. Тус албан татварыг төлөвлөөгүйгээс орон нутгийн төсвийн орлого, урсгал зардал буруу тооцоологдох эрсдэлтэй байна.

<sup>4</sup> 5.1.Албан татвар төлөгчийн өмчилж буй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулна.

<sup>5</sup> Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн татварын алба тооцож, төлбөл зохих албан татварыг тодорхойлно.

<sup>6</sup> Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хот, сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвөөс бүрдэнэ.

<sup>7</sup> Татварын орлого нь Татварын ерөнхий хуулиар тогтоосон албан татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.



- 1.11 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1<sup>8</sup>-д заасны дагуу аймгийн ИТХ-ын 2022 оны 60 дугаар тогтоолоор үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь хэмжээг тогтоосон байна.
- 1.12 Сангийн яамны хянасан дүнгээр үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогыг 490.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.
- 1.13 Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татварыг аймгийн ИТХ-ын 2022 оны 61 дүгээр тогтоол, Авто тээврийн үндэсний төвд бүртгэлтэй 17,848 тээврийн хэрэгслийн бүртгэлд үндэслэн 587.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцсон байна.
- 1.14 Цагдаагийн газраас ирүүлсэн тоо мэдээлэлд үндэслэн, галт зэвсгийн албан татвар 41.2 сая төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.
- 1.15 **Бусад нийтлэг төлбөр, хураамжийн албан татварын орлогыг 2025 оны тодотгосон төсвөөс 129.4 сая төгрөгөөр бууруулан, 557.2 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.**
- 1.16 Улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг өмнөх оны гүйцэтгэл, тайлант оны хүлээгдэж буй гүйцэтгэлийг үндэслэн 197.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.
- 1.17 Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг орон нутагт баригдаж буй барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээтэй харьцуулахад тооцоолол судалгаагүйгээр 50.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.
- 1.18 Есөнбулаг суманд байрлах улсын нөөцийн болон орон нутгийн тусгай хамгаалалттай газарт иргэн, хуулийн этгээд зөвшөөрөлгүй түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглаж буй хууль бус олборлолтод төрийн байгууллага, ажил хариуцсан албан тушаалтнууд хяналт хэрэгжүүлж, зөрчлийг арилгах шаардлагатай байна.
- 1.19 Уул уурхайн нөхөн сэргээлтийн сангийн үйл ажиллагаа, үр дүн, үр нөлөөд хийсэн нийцлийн аудитаар 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдөр дээрх зөрчлийг арилгах 14/214 дугаар албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн.
- 1.20 Хог хаягдлын хураамжийн төлбөрийг өмнөх оны гүйцэтгэл, тайлант оны хүлээгдэж буй гүйцэтгэлийг үндэслэн 310.2 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.
- 1.21 **Газрын төлбөрийн орлогыг 2025 оны тодотгосон төсвөөс 334.7 сая төгрөгөөр бууруулан, 1,826.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.**
- 1.22 Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн тоо мэдээлэлд үндэслэн газрын төлбөрийн орлогыг өмнөх оны өр төлбөр 91.9 сая төгрөг, 2026 онд шинээр олгох газар олголтоос 18.6 сая төгрөг, нийт **110.5** сая төгрөгөөр орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна. (Дэлгэрэнгүйг хавсралт №2-оос үзнэ үү)
- Сумдад ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж буй аж ахуйн нэгжийн газрын эрхийг баталгаажуулснаар газрын төлбөрийн орлогыг нэмэгдүүлэх боломж байна.

8 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан үнэлгээнээс аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн хөрөнгийн байршил, зориулалт, хэмжээ, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байдлыг харгалзан 0.6-2.0 хувиар тооцож ногдуулна



1.23 Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, дуудлага худалдаа явуулах журам”-ын дагуу газрын дуудлага худалдааны орлогоос 228.4 сая төгрөгийг төвлөрүүлэхээр тооцсон байна.

1.24 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 2025 оны тодотгосон төсвөөс 174.5 сая төгрөгөөр бууруулан, 1,535.2 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

1.25 Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг Сангийн яамны хянасан дүнгээр 0.7 сая төгрөгөөр тооцож, байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлогыг хянасан дүнгээс 0.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 3.1 сая төгрөгөөр тооцсон байна.

1.26 Ус рашаан ашигласны төлбөрийн орлогыг 1,187.6 сая төгрөгөөр төлөвлөсөн нь 2025 оны тодотгосон төсвөөс 374.4 сая төгрөгөөр, Сангийн яамны хянасан дүнгээс 1.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн тооцсон байна.

1.27 Байгаль орчны газрын тоо мэдээлэлд үндэслэн үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар үйл ажиллагаа явуулж байгаа 38 хуулийн этгээдийн усны нөөц ашигласны төлбөр **124.8** сая төгрөгөөр орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна. (Дэлгэрэнгүйг хавсралт №3-аас үзнэ үү)

Хүснэгт 1. Усны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, (сая төгрөг)

Он	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
2021 он	164.0	120.4	(43.6)
2022 он	182.8	128.7	(54.1)
2023 он	328.6	399.9	71.0
2024 он	508.1	564.8	56.7
2025 оны 10 сар	813.2	683.2	(130.0)

Эх сурвалж: Аймгийн 2021, 2022, 2023, 2024 оны төсвийн гүйцэтгэл, 2025 оны ХБГ

1.28 Цаашид иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаас байгалийн нөөц ашигласны төлбөрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцож, төсөвт бүрэн төвлөрүүлж, төсвийн орлогыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

1.29 Аймгийн Засаг даргаас өргөн барьсан 2026 оны төсвийн төсөлд тусгасан татварын орлогыг 1,444.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.

### Татварын бус орлого

1.30 Нийтлэг бус татварын орлогыг 2025 оны тодотгосон төсвөөс 357.6 сая төгрөгөөр бууруулан, 1,677.7 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Үүнд: Торгуулийн орлогыг 1,405.9 сая төгрөгөөр, хүүгийн орлогыг 38.0 сая төгрөгөөр, түрээсийн орлогыг 13.8 сая төгрөгөөр, бусад орлогыг 220.0 сая төгрөгөөр тооцсон байна.

1.31 Сангийн яамнаас төсөвт байгууллагын өөрийн орлогыг 8.3 сая төгрөгөөр хянасан боловч огт төлөвлөөгүй байна.

1.32 Цагдаагийн газар, Татварын газрын улсын байцаагчдын хяналт шалгалтаар өмнөх онуудад тогтоосон 691.2 сая төгрөгийн торгууль төлөгдөөгүй үлдэгдэлтэй байна. Төлөгдөөгүй торгуулиас 40.0 хувийг төвлөрүүлнэ гэж тооцвол **276.5** сая төгрөгөөр орлого нэмэгдэх боломж байна. (Дэлгэрэнгүйг хавсралт №4-өөс үзнэ үү)



1.33 Аудитаар төсвийн шууд захирагчдаас ирүүлсэн санал, тооцоололд үндэслэн 2025 оны төсвийн тодотголын дүн, өмнөх жилүүдийн гүйцэтгэлд тулгуурлан 2026 оны төсвийн төсөлд төсөвт байгууллагын өөрийн орлогыг **49.0** сая төгрөгийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна. Үүнд сумдын ЗДТГ-ын буудал, халуун ус, фитнес, автомат худаг, түрээсийн орлогыг тооцоолсон болно. *(Дэлгэрэнгүйг хавсралт №5-аас үзнэ үү)*

1.34 Хөрөнгийн орлогыг (өмч хувьчлалын орлого) 2025 оны тодотгосон төсвөөс 90.3 сая төгрөгөөр бууруулан, 60.0 сая төгрөгөөр тооцсон байна.

1.35 Аймгийн Засаг даргаас өргөн барьсан 2026 оны төсвийн төсөлд тусгасан татварын бус орлогыг **325.5** сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

### **ХОЁР. ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ, ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ ЗӨРЧСӨН 3,270.4 САЯ ТӨГРӨГИЙН УРСГАЛ ТӨСВИЙН ЗАРДЛЫГ ХАСАХ САНАЛТАЙ БАЙНА.**

2.1 Монгол Улсын 2026 оны төсвийн төслийн урсгал зардлын төлөвлөлтөд дараах бодлого, зарчмыг баримталсан байна.

- Удирдах албан тушаалтны орон тоог бууруулж, төрийн албан хаагчдын орон тооны тэлэлтийг хязгаарлах бодлогын хүрээнд цалингийн зардлын өсөлтийг хязгаарлах;
- Төрийн хэмнэлтийн бодлогыг үргэлжлүүлэх;

2.2 Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2026 оны төсвийн төслийг Засгийн газрын тогтоосон төсвийн хязгаараас 3,641.7 сая төгрөгөөр хэтрүүлэн төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1<sup>9</sup>, 27 дугаар зүйлийн 27.1.4<sup>10</sup>, 31 дүгээр зүйлийн 31.1.3<sup>11</sup> заалттай тус тус нийцэхгүй байна.

*Хүснэгт 2. Төсвийн зарлагын хязгаар, харьцуулсан судалгаа (сая төгрөг)*

Он	2025 он			2026 он		
	Хязгаар	Гүйцэтгэл /төсөв/	Зөрүү	Хязгаар	Төсвийн төсөл	Зөрүү
Суурь зарлага	58,984.4	66,975.6	(7,991.2)	51,052.6	54,694.3	(3,641.7)

*Эх сурвалж: Засгийн газрын тогтоол, Аймгийн Засаг даргаас өргөн барьсан 2026 оны төсвийн төсөл*

2.3 Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн хязгаарт багтаагүй саналаа төсвийн төслийн тооцоонд тусгахгүйгээр холбогдох үндэслэл, тайлбарын хамт ирүүлэхээр Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2<sup>12</sup> дахь хэсэгт заасан байна.

2.4 Төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллага болон сумын хөрөнгө оруулалтын нэгдсэн судалгаагүй, төсөв санхүүгийн бодитой мэдээллийг иж бүрэн нэгтгээгүй, жил бүр шинэчлэн сайжруулаагүй, хяналт хэрэгжүүлээгүй зэрэг нь шийдвэр гаргахад үндэслэлтэй, шаардлагатай нэгдсэн судалгаа, мэдээлэл дутмаг байгааг харуулж байна.

2.5 Төсвийн төслийн нийт урсгал зардлын 2.4 хувийг хөрөнгийн зардал, 97.6 хувийг бараа үйлчилгээний урсгал зардал эзэлж байна. Бараа үйлчилгээний урсгал зардлын 45.8

<sup>9</sup> жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах;

<sup>10</sup> 27.1.4 жилийн төсвийн хязгаарт үндэслэсэн байх;

<sup>11</sup> жилийн төсвийн хязгаарт багтаасан байх

<sup>12</sup> Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 31.1.3-т заасан хязгаарт багтаагүй саналаа төсвийн төслийн тооцоонд тусгахгүйгээр холбогдох үндэслэл, тайлбарын хамт ирүүлнэ



хувийг цалин, хөлс нэмэгдэл, урамшуулал, НДШ-ийн зардал, 32.1 хувийг тогтмол зардал, 17.5 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 1.0 хувийг хангамж, бараа материалын зардал, бусад 3.6 хувийг байгууллагын хэвийн үйл ажиллагааг явуулахтай холбоотой зардал тус тус эзэлж байна.

2.6 Аймгийн төсвийн 2021-2024 оны гүйцэтгэлээр зардлын дундаж өсөлтийг тооцож, 2026 оны төсвийн төслийг 2025 оны төсөвтэй харьцуулан шинжилгээ хийхэд:

- Цалингийн зардал дунджаар 30.0 хувийн өсөлттэй, 2025 оны тодотгосон төсвөөс 11.0 хувиар буурсан,
- Тогтмол зардал дунджаар 25.4 хувийн өсөлттэй, 2025 оны тодотгосон төсвөөс 19.0 хувиар буурсан,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлсний зардал дунджаар 67.0 хувийн өсөлттэй, 2025 оны тодотгосон төсвөөс 99.0 хувиар буурсан,
- Бараа үйлчилгээний бусад зардал дунджаар 155.0 хувийн өсөлттэй, 2025 оны тодотгосон төсвөөс 5 дахин их буюу 526.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


2.7 Төсвийн төсөлд тусгасан бараа үйлчилгээний бусад зардал нь өмнөх оноос 5 дахин нэмэгдэхээр байна. Энэ нь Засаг дарга ерөнхий данснаас санхүүжихээр 2026 онд 9,636.5 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлын ангилалд төлөвлөсөнтэй холбоотой байна.

2.8 Аймгийн дүнгээр 25,393.7 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор төлөвлөсөн нь 2025 оны баталсан төсвөөс 560.8 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

2.9 Сангийн яаманд Засаг дарга Ерөнхий данснаас мал эмнэлгийн үйлчилгээ 525.9 сая төгрөг, нийтийн тээврийн алдагдалд олгох татаас 11.4 сая төгрөг, ахмадын хорооны санхүүжилт 201.4 сая төгрөг, нийт 738.7 сая төгрөгийн зардал гаргахаар хянуулсан байна.

2.10 Гэвч төсвийн төсөлд Засаг дарга Ерөнхий данснаас 9,636.5 сая төгрөгийг зарцуулахаар төсөвлөсөн нь төсвийн хязгаарыг зөрчиж, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийг хэтрүүлж хууль тогтоомжийг мөрдөж ажиллахгүй байгааг харуулж байна.

Дүрслэл 4. Засаг дарга ерөнхий дансны зарцуулалтын судалгаа (сая төгрөгөөр)



Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.11 Засаг дарга Ерөнхий дансны санхүүжилт 2023 оноос хойш 3.6 дахин өсөж, 2026 оны төсвийн төсөлд 9,636.5 сая төгрөг байхаар төсөвлөжээ.

2.12 Төсвийн төсөлд цалин, тогтмол зардал зэргийг бууруулан тооцсон хэдий ч Засаг дарга дансны санхүүжилт буураагүй 568.3 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь Засгийн



газраас баримталж буй бодлого чиглэл, Төрийн хэмнэлтийн тухай хуультай нийцэхгүй байна.

2.13 Аймгийн 2026 оны төсвийн төсөлд Засаг дарга Ерөнхий данснаас Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцээгүй, Сангийн яамаар хянуулаагүй, тооцоо судалгаагүй, төсөвлөлтийн шаардлага хангахгүй 2,733.2 сая төгрөгийн урсгал зардлыг хасах санал хүргүүлж байна. Үүнд:

- Урсгал зардлын төсвөөс Засаг даргын мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээнд 2,285.6 сая төгрөгийг бодит тооцоо судалгаагүй, хүрэх үр дүн тодорхой бус, хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэх,
- Аймгийн баяр наадмын зардлыг өмнөх оны төлөвлөгөөнд үндэслэн төлөвлөсөн байна. Баяр наадмын 2025 оны гүйцэтгэлээр Ёслол хүндэтгэл, аж ахуйн салбар хороонд 75.0 сая төгрөгийг, Наадмын соёл урлаг, спортын салбарын хороонд 62.8 сая төгрөгийг, Хэвлэл мэдээлэл сурталчилгаа хариуцсан салбар хороонд 22.3 сая төгрөгийг нийт 160.1 сая төгрөгийн зарцуулсан байна. Дээрх зардлуудыг 50.0 хувь буюу 80.0 сая төгрөгөөр бууруулах,
- Жангар тууль хайлахад 98.3 сая төгрөг, Жангар фестиваль, залуучуудын чуулга уулзалт зохион байгуулахад 106.3 сая төгрөг, нийт 204.6 сая төгрөгийг бодит тооцоо судалгаагүй, хүрэх үр дүн тодорхой бус, хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэх,
- Бугат сумын Эрүүл мэндийн төвд 83.0 сая төгрөгийн төсвийн дэмжлэгийг олгох,
- Залуу гэр бүлийг малжуулах арга хэмжээнд 80.0 сая төгрөгийг буцалтгүй дэмжлэг олгохоор тус тус төсөвлөсөн байна.

2.14 Монгол Улсын 2025 оны төсвийн тодотголд баримталсан бодлого, Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлд заасны дагуу төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9.0 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлэх бодлого хэрэгжиж байна.

2.15 Аймгийн хэмжээнд төрийн албан хаагчдыг орон тоог цомхотгоогүй, харин Сангийн яамнаас төсөвт байгууллагын цалингийн зардлыг 9.0 хувиар бууруулж баталж өгсөнтэй холбоотойгоор цалингийн зардлыг 9.0 хувиар бууруулсан байна.

2.16 Аймгийн 2026 оны төсвийн төсөлд орон тооны тэлэлтийг хязгаарлах, 2025 оны тодотгосон төсөвт баримталсан төрийн албан хаагчдын орон тоог 9.0 хувиар бууруулах бодлогыг үргэлжлүүлэн баримталсан.

2.17 Засгийн газраас тогтоосон орон тооны хязгаараас 12 орон тоо илүү ажиллуулж буй дараах байгууллагуудын 437.2 сая төгрөгийн цалингийн зардлыг бууруулах саналтай байна. Үүнд:

- Аймгийн ЗДТГ-ын Засаг даргын зөвлөх 1, хэвлэл мэдээллийн албаны 3, нийт 4 орон тооны цалин, НДШ-ийн зардалд төсөвлөсөн 184.0 сая төгрөгийг,
- Аймгийн ИТХ-ын 8 орон тооны цалин, НДШ-ийн зардалд төсөвлөсөн 253.1 сая төгрөгийг тус тус бууруулах.



2.18 Эдгээр хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр төсөвлөсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.4<sup>13</sup>, Засгийн газрын 2021 оны 376 дугаар тогтоол, 2025 оны 37 дугаар тогтоолыг тус тус зөрчсөн байна.

2.19 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор зардлыг хэрэгцээ, шаардлагад үндэслэн, эрэмбэлэн төлөвлөх шаардлагатай байна.

2.20 Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тогтоолоор баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-аар аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нөөц хөрөнгийг төсөвлөж, зарцуулах зохицуулалттай байна.

2.21 Харин аймгийн 2026 оны төсвийн төсөлд аймгийн ИТХ-ын төсөвт 100.0 сая төгрөгийн нөөц хөрөнгийг зарцуулахаар төсөвлөснийг хасах шаардлагатай байна.


2.22 Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.4.2-т “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлэх” гэж тусгасан зорилгын хүрээнд орон нутгийн өмчит аж ахуй нэгжүүдийн үр ашгийг дээшлүүлэх, бие даасан байдлаа хангадаг байхад анхаарч ажиллах шаардлага үүсэж байна.

2.23 Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот газруудаас 2023 онд Солонго дулааны станц ААТҮГ 10.3 сая төгрөгийн, Алтай орон сууцны корпорац ААТҮГ 1,075.3 сая төгрөгийн, Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв УТҮГ 59.7 сая төгрөгийн, 2024 онд Алтай хотын тохижилт үйлчилгээний газар ААТҮГ 1,021.5 сая төгрөгийн, Инноваци судалгаа, бизнес хөгжлийн төв УТҮГ 2.2 сая төгрөгийн, Нийтлэг үйлчилгээ УТҮГ 96.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

2.24 Аймгийн ИТХ-ын 2020 оны 75 дугаар тогтоолоор Инноваци судалгаа, бизнес хөгжлийн төвийг байгуулж, төсвийн 100.0 хувийн татаасаар үйл ажиллагааг явуулж байна. Орон нутгийн төсвөөс олгох татаасыг 2021 оноос хойш 11.5 дахин нэмэгдэж, 2026 оны төсвийн төсөлд 551.6 сая төгрөгийг олгохоор төлөвлөсөн байна.

2.25 Тус аж ахуйн нэгж нь инновацийг хэрэглээнд нэвтрүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх, өрсөлдөх чадварыг бий болгох, нийгмийн үйлчилгээг сайжруулах зорилгоо бүрэн хангаж, хэрэгжүүлсэн ажил нь үр дүнд хүрсэн эсэхийг дүгнэж, үр ашгийг тооцож байх шаардлагатай байна.

Дүрслэл 5. Инноваци судалгаа бизнес хөгжлийн төвийн санхүүжилт (сая төгрөг)



Эх сурвалж: Санхүүгийн тайлан, Аймгийн Засаг даргаас өргөн барьсан 2026 оны төсвийн төсөл

<sup>13</sup> Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно.



2.26 Аймгийн ИТХ-ын 2025 оны 04 дүгээр тогтоолоор Теле камерын хяналтын дэд төв ААТҮГ-ыг 6 орон тоотойгоор шинээр байгуулж, Засаг дарга ерөнхий данснаас 2026 онд 187.1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор төлөвлөсөн байна.

2.27 Аймгийн ИТХ-ын тогтоолоор байгуулан төсвөөс 100.0 хувийн татаас олгодог ААТҮГ-уудын ашигт ажиллагаа, үйл ажиллагааны үр дүнг үнэлж тооцдоггүй, татаасыг жил бүр нэмэгдүүлсээр байна.

2.28 Аймгийн Засаг даргаас өргөн барьсан 2026 оны төсвийн төсөлд тусгасан урсгал төсвийн зардлыг 3,270.4 сая төгрөгөөр хасах саналтай байна.

## **ГУРАВ. ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.**

3.1. Монгол Улсын 2026-2030 онд баримтлах таван жилийн үндсэн чиглэл, хөрөнгө оруулалтын хөтөлбөр батлагдаагүй, боловсруулах үе шатанд байна.

3.2. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон 5 жилийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжих хугацаа дуусаж байгаа тул 2026 оны төсвийн төслийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг дунд хугацааны бодлогын дээрх баримт бичгүүдтэй уялдсан эсэхэд дүгнэлт гаргах боломжгүй байна.

### **Орон нутгийн хөгжлийн сан**

3.3. ОНХС-ийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгддэг.

3.4. ОНХС-ийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан танилцуулаагүй, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулаагүй, нэгдсэн жагсаалтыг хуульд заасан хугацаанд Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээгүй нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтын 7 дугаар зүйлийн 7.5<sup>14</sup>, 7.6<sup>15</sup> дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

3.5. Аудитад сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт, шаардлагатай баримт материалыг хамруулаагүй болно.

3.6. Аймгийн ОНХС-гаас 2026 онд 31 төсөл, арга хэмжээг 8,154.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнээс он дамжин хэрэгжих 18 төсөл, арга хэмжээг 6,135.4 сая төгрөгөөр, шинээр хэрэгжих 13 төсөл, арга хэмжээг 2,019.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төсөвлөжээ. Мөн Бигэр сумын сургууль спорт заалны барилгыг дулаан хангамжид холбох ажил, Хөгжил хорооллын дулааны эх үүсвэрт холболт хийх төсөл, арга хэмжээнд 2025 онд Магадлалын дүгнэлтээс дутуу санхүүжихээр төсөвлөсөн байгаа анхаарах шаардлагатай байна.

<sup>14</sup> “урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан, нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг жил бүрийн 7 дугаар сард багтаан зохион байгуулна”

<sup>15</sup> “Ажлын хэсэг хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг ОНХС-ийн УМС-ийн маягтын дагуу хэвлэж жил бүрийн 8 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ”





Хүснэгт 3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө (сая төгрөг)

Ангилал	Шинэ төсөл, арга хэмжээ			Шилжих төсөл, арга хэмжээ			Нийт төсөл, арга хэмжээ		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга, байгууламж	7	1,942.6	1,146.5	14	6,777.0	5,291.3	21	8,719.6	6,437.8
Их засвар	1	1,139.7	563.5	2	1,610.2	611.1	3	2,749.9	1,174.5
Тоног төхөөрөмж	1	99.4	99.4	1	200.0	200.0	2	299.4	299.4
ТЭЗҮ	4	209.8	209.8	1	33.0	33.0	5	242.8	242.8
Нийт	13	3,391.4	2,019.1	18	8,620.2	6,135.4	31	12,011.6	8,154.5


Эх сурвалж: Аймгийн Засаг даргаас өргөн барьсан 2026 оны төсвийн төсөл

3.7. Үндэсний статистикийн хорооны 2020–2024 оны хүн амын шилжих хөдөлгөөний статистик мэдээллээс харахад сүүлийн 5 жилд Говь-Алтай аймгаас 7,372 иргэн шилжиж явсан, 1,723 иргэн шилжиж ирсэн байна. Жил бүр сөрөг шилжилттэй, өөрөөр хэлбэл шилжин ирэгсдийн тоо шилжин явсан хүний тооноос 4 дахин бага байна.

Дүрслэл 6. Аймгийн хүн амын шилжилт хөдөлгөөн Дүрслэл 7. ОНХС-ийн санхүүжилт, гүйцэтгэл (сая төг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо



Эх сурвалж: ТЭЗ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.8. Аймгийн хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөнд тусгаагүй 21 төсөл, арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр байгаа нь хөгжлийн бодлого оновчтой бус, иргэдэд хэрэгцээ шаардлагатай үр өгөөж өгөх хөрөнгө оруулалт болж чадахгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.1.1<sup>16</sup> дахь заалттай нийцэхгүй байна. (Дэлгэрэнгүйг хавсралт №-6-аас үзнэ үү)

3.9. ОНХС-ийн хөрөнгөөр 2026 онд санхүүжүүлэхээр төлөвлөсөн 541.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаагүй, 762.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 арга хэмжээ нь ажлын зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, хуульд заасан бусад зөвшөөрөлгүй байна.

Хүснэгт 4. ОНХС-ийн төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ (сая төгрөг)

<b>Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй</b>	<b>Ажлын зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, хуульд заасан бусад зөвшөөрөлгүй</b>
--	---

<sup>16</sup> "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх"



Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
Жангар нийтийн номын сангийн засварын ажил”	491.1	291.1	Хуучин насос станцаас нарлаг төвийн урд тал хүртэлх цэвэр усны шугамыг хэсэгчлэн солих ажил	612.1	200.0
Халиун сумын цэвэрлэх байгууламжийг гадна цахилгаан хангамжид холбох ажлын үлдэгдэл санхүүжилт	50.0	50.0	Аюулгүйн тойргоос Минж зочид буудал хүртэлх гудамж дахин төлөвлөлтөд хийх, барилгажилтын төсөл боловсруулах	150.0	150.0
<b>Дүн</b>	<b>541.1</b>	<b>341.1</b>		<b>762.1</b>	<b>350.0</b>

Эх сурвалж: Аймгийн Засаг даргаас өргөн барьсан 2026 оны төсвийн төсөл

3.10. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 689.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээний ашиглалттай холбоотой урсгал зардал, санхүүжүүлэх эх үүсвэрийн тооцоог гаргаагүй. Үүнд:

- *Жаргалан-Алтай өрхийн Эрүүл мэндийн төвийн өргөтгөл-555.3 сая төгрөг,*
- *Шарга сумын Хүүхдийн цэцэрлэгт худаг гаргах -35.0 сая төгрөг,*
- *Сүүний үйлдвэрийн тоног, төхөөрөмж нийлүүлэх-99.4 сая төгрөгийн арга хэмжээ байна.*

3.11. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.1.6<sup>17</sup> дахь заалттай нийцэхгүй байна.

### Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

3.12. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжиж эхэлсэн Алтай сумын төвд баригдах 1 км хатуу хучилттай автозамын ажлыг 2026 онд 185.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төсөвлөсөн байна. Энэ нь аймгийн хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

### Авто замын сангийн хөрөнгө оруулалт

3.13. Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тусгасан 8 төсөл, арга хэмжээг аймгийн хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөнд тусгаагүй байна. Энэ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.4<sup>18</sup>- заалттай нийцэхгүй байна.

3.14. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль тогтоомжид заасны дагуу төлөвлөхгүй байгаа нь хөрөнгийн үр ашиг, үр өгөөжийг бууруулах эрсдлийг бий болгож байна.

<sup>17</sup> Аймаг, нийслэлийн ОНХС-ийн ажлын хэсэг нь тус сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргасан байх;

<sup>18</sup> "орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх"



3.15. Бүх шатны ИТХ-аар хууль, тогтоомжид нийцсэн, иргэд олон нийтийн саналаар дэмжигдсэн, нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой, төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг хэлэлцэн батлах шаардлагатай байна.

**Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн талаар:**

3.16. Төрийн аудитын байгууллага нь Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу өмнөх аудитын тайланд дурдсан асуудал, зөвлөмжийн мөрөөр хариуцагч талын авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийх үүрэгтэй.

3.17. Өмнөх аудитаар аймгийн ИТХ-д 3, сумын ИТХ-д 1, аймгийн Засаг даргад 8 зөвлөмж хүргүүлснээс 6 нь хэрэгжиж, 1 зөвлөмж хэрэгжих шатандаа, 5 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, 54.0 хувьтай байна. (Дэлгэрэнгүйг хавсралт №7-оос үзнэ үү)

3.18. Аймгийн Засаг даргаас Төрийн аудитын газарт дүгнэлт гаргахаар ирүүлсэн 2025 оны төсвийн төсөлд тусгаагүй, 279.2 сая төгрөгийн арга хэмжээг санхүүжүүлэхээр аймгийн ИТХ-д батлуулахаар өргөн барьсан байна. Үүнд:

- Бугат сумын Эрүүл мэндийн төвд дэмжлэг 117.2 сая төгрөг,
- Соёл урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах хүрээнд Ардын дуу бүжгийн Алтай чуулгад дэмжлэг-93.0 сая төгрөг,
- Төр нийгмийн зүтгэлтэн, гавьяат эдийн засагч Ц.Лоохууз агсны мэндэлсний 100 жилийн ойн арга хэмжээний зардал-50.0 сая төгрөг,
- Баян-Уул сумын Алтангадас багийн төвийн засварын зардал-19.0 сая төгрөгийг Төрийн аудитын байгууллагаас дүгнэлт гаргуулахгүйгээр төсөвлөж батлуулсан.

**ДҮГНЭЛТ:**

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс болон аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна.

1. Татварын болон татварын бус орлогыг 1,770.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.
2. Малын тоо толгойн албан татварын орлогыг огт төлөвлөөгүй нь төсвийн иж бүрэн байдлыг хангахгүй, төсвийн төлөвлөлтийн үр ашгийг бууруулж байна.
3. Төсвийн төсөлд урсгал зардлыг 54,694.3 сая төгрөг буюу төсвийн хязгаараас 3,641.7 сая төгрөгөөр хэтрүүлэн төлөвлөсөн байна.
4. Засаг дарга Ерөнхий дансны санхүүжилт 2023 оноос хойш 3.6 дахин өсөж, 2026 оны төсвийн төсөлд 9,636.5 сая төгрөг зарцуулахаар төсөвлөсөн нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцэхгүй байна.
5. Төрийн хэмнэлтийн бодлогыг баримтлаагүй, төсөвлөлтийн шаардлага хангахгүй, хөтөлбөрийн хүрэх үр дүн тодорхойгүй, тооцоо судалгаанд үндэслээгүй 3,270.4 сая төгрөгийн урсгал зардлын төсвийг хасах шаардлагатай байна.
6. Аймгийн ИТХ-ын тогтоолоор байгуулсан орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдэд төсвөөс олгох татаас жил бүр нэмэгдэж байгаа нь орон нутгийн төсөвт ачаалал үүсгэж байна.
7. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан танилцуулаагүй, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулаагүй, нэгдсэн жагсаалтыг хуульд заасан хугацаанд Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээгүй байна.



8. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаагүй 2 төсөл, арга хэмжээ, Аймгийн хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөнд тусгаагүй 21 төсөл, арга хэмжээг төсөвлөсөн нь дунд хугацааны хөгжлийн бодлого, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэгдээгүй байна.
9. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 2 ажлын зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, хуульд заасан бусад зөвшөөрөлгүй, 3 төсөл, арга хэмжээний ашиглалтын зардлыг тооцоогүй, санхүүжүүлэх эх үүсвэр тодорхойгүй байна.
10. Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төсөвлөсөн 2 төсөл, арга хэмжээг Аймгийн хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөнд тусгаагүй байна.

### **ЗӨВЛӨМЖ:**

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

#### **Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд толилуулах нь:**

1. Төсвөөс татаас авч үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн өмчит аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагааны үр дүнд хяналт хэрэгжүүлж, аймгийн нийгэм, эдийн засагт үр өгөөжгүй, үр ашиггүй, татаасаар бүрэн санхүүждэг аж ахуйн тооцоот газруудыг нэгтгэх, бүтцийн өөрчлөлт хийх ажлыг зохион байгуулах.
2. Аймгийн хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгасан, төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг батлах.
3. Төсвийн үр ашгийг дээшлүүлж, хууль, тогтоомжид нийцүүлэн, төрийн хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэн, тэвчиж болох зардлыг батлахгүй байх арга хэмжээг авч ажиллах.

#### **Аймгийн Засаг даргад:**

1. Сумдын төсөвт малын тоо толгойн албан татварын орлогыг төлөвлөх ажлыг зохион байгуулах.
2. Төсвийн тухай хуулийг мөрдөж, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн, Засгийн газрын тогтоосон хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.
3. Тухайн жилийн төсвийн төслийг боловсруулахдаа хөрөнгө оруулалтын арга хэмжээг аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулах.



## ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ ТАЙЛБАР



### ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Жинст баг, Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82093  
Утас/Факс: 7048-4042, Цахим шуудан: info@govi-altai.gov.mn  
Цахим хуудас: www.govi-altai.gov.mn

2025. 11. 24 № 3/1587

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд өгсөн шийдвэрийн саналыг хүргүүлж байна.  
Хавсралт 2- хуудастай.

ДАРГА

Ш.ЭРДЭНЭБАТ

D:\jil\heltse\TD\A5





## ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

д/д	Хариу тайлбар	Тайлбар
1.	Боловсролын газрын 2026 төсвийн төслийн саналаар нэмэгдүүлсэн байна. Энэ нь батлагдсан шийдвэр биш тул энэхүү заалтыг хасаж өгнө үү.	Саналыг хүлээн авч 667.1 сая төгрөгөөр бууруулж 800.0 сая төгрөгийн цалингийн ашиг төсөвт төвлөрөхөөр байна.
2.	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар үйл ажиллагаа явуулдаг 38 хуулийн этгээдээс 309.3 сая төгрөгийн ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогыг нэмэгдүүлэхээр байгааг оруулах боломжгүй.	Төрийн аудитын тухай хуулиар 6 дугаар зүйлийн 6.3.2-т зааснаар төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх санал гаргахаар заасан. Гэтэл ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын төсвийн төсөлд үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар үйл ажиллагаа явуулдаг 5 хуулийн этгээдийн ус ашигласны төлбөрийн орлогыг 183.5 сая төгрөгөөр буруу тооцоолсон дүнг хасаж санал оруулаагүй. Асуудлын бүртгэлийн дагуу санал ирсэн тул буруу тооцоолсон дээрх дүнгийн орлогыг хасаж орлого нэмэгдүүлэх саналыг 125.8 сая төгрөг болгон бууруулсан.
3.	Малын тоо толгойн албан татварын хэмжээг сумын ИТХ-аар батлан төсвийн орлогод төвлөрүүлж, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр болгон иргэдээс санал авч зарцуулдаг учир аймаг төлөвлөх боломжгүй. Сумдад төлөвлүүлэх үүрэг чиглэлийг өгч ажиллана.	Малын тоо толгойн албан татвар нь орон нутгийн төсвийн орлогын нэг хэсэг тул уг орлогыг төлөвлөх ёстой. Иймд саналыг хүлээн авах боломжгүй.
4.	Сумдын Засаг даргын Тамгын газар өөрийн орлогыг төлөвлөж манай хэлтэст ирүүлээгүй. Сумдад төлөвлүүлэх үүрэг чиглэлийг өгч ажиллана.	Сумдын Засаг даргын Тамгын газар өөрийн орлого нь орон нутгийн төсвийн орлогын нэг хэсэг тул уг орлогыг төлөвлөх ёстой тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
5.	Аймгийн Засаг даргын 2025 оны А/325 дугаар захирамжаар батлагдсан төсөл арга хэмжээний зардлыг зарцуулах шийдвэр гарсан тул уг зардлыг хасаж өгнө үү.	Саналыг хүлээн авах боломжгүй.
6.	Орон нутгийн төсвөөс баяр наадмын зардал гаргаж болохгүй гэсэн заалт байхгүй мөн ОНХС-д эх үүсвэр байхгүй тул орон нутгийн төсвөөс гаргахаар төлөвлөсөн тул хасаж өгнө үү.	Саналын дагуу 2026 оны баяр наадмын зардлыг 80.0 сая төгрөгөөр хасах саналыг хүргүүллээ.
7.	Үр ашиг: 1.Алтайн бахархал өв соёлыг түгээн дэлгэрүүлэхэд Жангар тууль хайлах брэнд арга хэмжээ болсон мөн Жангар фестиваль, залуучуудын чуулга уулзалт бол залуучуудыг дэмжлэг томоохон ажил тул уг 204.6 сая төгрөгийг хасаж өгнө үү.	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй.
8.	Бугатын тахийн тал сумын төвөөс 80 км зайтай хөдөөгийн малчин өрхөд эрүүл мэндийн тусламж үзүүлэхэд зайлшгүй шаардлага байгаа тул 1 эмч 1 сувилагч,1	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй.



9.	Аймгийн ИТХ-ын 2023 оны 02 дугаар тогтоолын дагуу залуу гэр бүлийг малжуулах арга хэмжээнд буцалтгүй дэмжлэгийг 2025 онд 150.0 сая төгрөг төлөвлөж өгч байсан 2026 онд 50.0 хувийг сумаас 50.0 хувийг аймгаас гаргахаар болсон тул хасаж өгнө үү.	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй.
10.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар 1 тэрбум мод үндэсний хөдөлгөөн 108 сая мод аймаг тарьж ургуулах хөтөлбөрийн хүрээнд зардлыг тусгасан тул хасаж өгнө үү.	Саналыг хүлээн авч зөрчлөөс хаслаа.
11.	Аймгийн санхүүгийн салбарын ажилтнуудыг чадавхжуулахад 30.0 сая төгрөгийг төсөвлөсөн зардлыг хасаж өгнө үү.	Саналыг хүлээн авч зөрчлөөс хаслаа.
12.	ИТХ-ын бараа үйлчилгээний бусад зардалд төсөвлөсөн нөөц хөрөнгийн 100.0 сая төгрөгийн зардал бууруулах саналыг хасаж өгнө үү.	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй.
13.	ЗЗНДНТУТ хуулийн дагуу аймгийн Засаг дарга хэвлэлийн алба байж болно гэж заасан тул хэвлэлийн 3 орон тоог УТ цалинжуулж байгаа тул хасаж өгнө үү.	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй.
14.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн 8 албан хаагчийн цалин, НДШ-ийн зардалд 253.0 сая төгрөгийн зардал бууруулах саналыг хасаж өгнө үү.	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй.



## Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлогыг нэмэгдүүлэх санал

мянган төгрөг

Байгууллага	2025 оны батлагдсан төсөв	2026 оны төсвийн төсөл	Нэмэгдүүлсэн дүн /БШУЯ-аас цалинг 6 хувиар нэмэгдүүлж төсвийн санал авсан/	НДШ	Цалингийн ашиг	Орлого нэмэгдүүлэх санал
Сургууль	42,943,591.9	53,163,171.0	10,219,579.1	1,175,251.6	587,992.8	300,000.0
Цэцэрлэг	17,658,364.4	29,300,839.4	11,642,475.0	1,338,884.6	879,159.0	500,000.0
<b>Нийт</b>	<b>60,601,956.3</b>	<b>82,464,010.5</b>	<b>21,862,054.2</b>	<b>2,514,136.2</b>	<b>1,467,151.8</b>	<b>800,000.0</b>

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## Газрын төлбөрийн орлогыг нэмэгдүүлэх санал

мянган төгрөг

Д/Д	Сумын нэр	Өмнөх оны үлдэгдэлээс /55 хувь/	2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл	2026 оны газар олголтын төлөвлөгөөний дагуу орох орлого	Нийт газрын төлбөрийн орлогын дүн	Аймгийн санал	Орлого нэмэгдүүлэх санал
1	Алтай	2,793.1	7,450.7	-	10,243.7	7,450.6	2,793.1
2	Баян уул	3,457.2	8,810.7	1.1	12,269.0	8,792.7	3,476.3
3	Бигэр	498.7	6,439.1	269.4	7,207.2	6,801.2	406.0
4	Бугат	5,459.0	13,790.5	15,775.4	35,024.8	13,772.0	21,252.8
5	Дарив	2,114.7	5,052.4	-	7,167.1	5,033.7	2,133.4
6	Дэлгэр	8,210.8	21,246.9	-	29,457.7	21,218.6	8,239.1
7	Жаргалан	995.4	8,309.0	-	9,304.4	8,200.3	1,104.1
8	Тайшир	7,575.2	50,533.5	1,569.2	59,677.9	50,683.5	8,994.4
9	Тонхил	2,658.4	12,445.6	70.9	15,174.9	12,445.6	2,729.3
10	Төгрөг	4,820.2	31,535.2	-	36,355.5	71,215.5	-34,860.1
11	Халиун	11,312.3	13,104.8	-	24,417.1	13,134.1	11,282.9
12	Хөхморьт	2,653.4	11,225.1	-	13,878.6	11,243.5	2,635.1
13	Цогт	4,811.8	16,550.5	23.9	21,386.1	16,584.5	4,801.6
14	Цээл	1,879.1	202,953.6	-	204,832.7	175,000.0	29,832.7
15	Чандмань	3,378.1	112,741.6	-	116,119.7	112,741.6	3,378.1
16	Шарга	4,141.4	6,832.7	5.8	10,979.9	6,811.7	4,168.2
17	Эрдэнэ	738.9	8,979.7	-	9,718.5	6,789.0	2,929.5
18	Есөнбулаг	24,417.3	1,288,045.0	910.0	1,313,372.2	1,278,128.3	35,243.9
	<b>Нийт дүн</b>	<b>91,914.8</b>	<b>1,826,046.4</b>	<b>18,625.7</b>	<b>1,936,586.9</b>	<b>1,826,046.4</b>	<b>110,540.5</b>

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

821744130  
11048010000000000000

## Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого нэмэгдүүлэх санал

мянган төгрөг

Д/д	Сумын нэр	Ус ашиглагч байгууллагуудын нэр	Орлого нэмэгдүүлэх санал /- буруу төлөвлөлттэй/	Тайлбар
1	Алтай	Зөөлөн Ресурс	602.1	Орлого дутуу төлөвлөсөн
2	Алтай	Эн Си Жи Ти ХХК	(5,339.6)	Ус ашиглуулах дүгнэлтээс илүү орлого төлөвлөсөн
3	Алтай	Ар Эм Си трэйд	529.4	Ус ашиглах дүгнэлттэй, орлого төлөвлөөгүй
4	Алтай	БХДБ	5,990.8	Ус ашиглах дүгнэлттэй, орлого төлөвлөөгүй
5	Алтай	Дунфанг хуйжин	5,808.1	Ус ашиглах дүгнэлттэй, орлого төлөвлөөгүй
6	Алтай	МОЭНКО	296.1	Орлого төлөвлөөгүй
7	Алтай	Өү Жи Си Эйч Эл	1,766.3	Орлого төлөвлөөгүй
8	Бигэр	Говийн гал голомт	916.7	Орлого төлөвлөөгүй
9	Бигэр	Монголиан майнинг энд минерал индастри	1,766.3	Орлого төлөвлөөгүй
10	Бигэр	"Номин эрдэнийн Өргөө" ХХК	5,569.1	Ус ашиглах дүгнэлттэй, орлого төлөвлөөгүй
11	Бугат	Цогц эрин транс	(21,480.0)	үйл ажиллагаа явуулаагүй, ус ашиглах дүгнэлттүй
12	Бугат	Эй СиБи" ХХК болж нэр	1,766.3	Орлого төлөвлөөгүй
13	Бугат	Дийпсурвэй	779.7	Ус ашиглах дүгнэлттэй, орлого төлөвлөөгүй
14	Бугат	Эм Си Жэй Майнинг	129.9	Ус ашиглах дүгнэлттэй, орлого төлөвлөөгүй
15	Есөнбулаг	Шадар туслагч	1,141.4	Орлого төлөвлөөгүй
16	Есөнбулаг	Амар-Алтай	1,000.0	Орлого төлөвлөөгүй
17	Есөнбулаг	Болд гянт болд ХХК	98,613.8	Ус ашиглуулах дүгнэлтээр төлөвлөөгүй, дутуу төлөвлөсөн
18	Есөнбулаг	Рийлзоин ресурс	966.8	Орлого дутуу төлөвлөсөн
19	Есөнбулаг	341 дүгээр анги	121.8	Ус ашиглах дүгнэлттэй, орлого төлөвлөөгүй
20	Жаргалан	Хүнхэр амралт	363.9	Орлого дутуу төлөвлөсөн
21	Тайшир	Тайшир Гуулин УЦС	(57,774.3)	Ус ашиглуулах дүгнэлтээс илүү орлого төлөвлөсөн
22	Тайшир	Цэн газар	311.2	Орлого дутуу төлөвлөсөн
23	Тайшир	Рагнарок инвистмент	(4,510.2)	Ус ашиглуулах дүгнэлтээс илүү орлого төлөвлөсөн
24	Тайшир	Содгазар	1,766.3	Орлого төлөвлөөгүй
25	Тайшир	Хос кварц	1,766.3	Орлого төлөвлөөгүй
26	Төгрөг	Цэрдийн тал	1,334.0	Ус ашиглах дүгнэлттэй, орлого төлөвлөөгүй
27	Цогт	Эдрэн гоулд ресурс	672.3	Орлого дутуу төлөвлөсөн
28	Цогт	Хан хэнтийн хүдэр	523.9	Орлого дутуу төлөвлөсөн
29	Цогт	Ресурспартнерис	4,872.7	Орлого дутуу төлөвлөсөн
30	Чандмань	Тахь Ресурс	894.3	Орлого дутуу төлөвлөсөн
31	Чандмань	Сэкер Ресорсус Монголиа	392.6	Орлого дутуу төлөвлөсөн
32	Шарга	Өрнөх алтай	1,766.3	Орлого төлөвлөөгүй
33	Эрдэнэ	Дүзо назо ХХК	916.7	Орлого төлөвлөөгүй
34	Эрдэнэ	Би жи ботнон гол	(3,874.5)	Ус ашиглуулах дүгнэлтээс илүү орлого төлөвлөсөн
35	Эрдэнэ	Ланд Оре ХХК	7,787.9	Орлого дутуу төлөвлөсөн
36	Эрдэнэ	Минтекминералс	1,766.3	Орлого төлөвлөөгүй
37	Эрдэнэ	монголиа	1,766.3	Орлого төлөвлөөгүй
38	Есөнбулаг	Мандал голомт ХХК	34,803.0	өмнөх онуудын өр төлбөртэй, аудитаар акт тогтоосон
39	Цээл	Цагаан марбл ХХД	28,332.0	өмнөх онуудын өр төлбөртэй, аудитаар акт тогтоосон
	<b>Нийт</b>		<b>124,821.8</b>	

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## Торгуулийн орлогыг нэмэгдүүлэх санал

мянган төгрөг

д/д	Төвлөрүүлэгч байгууллагын нэр	Торгуулийн ангилал, төрөл	Торгууль хамаарах огноо		Ногдуулсан	Төвлөрүүлсэн	Төвлөрүүлээгүй үлдэгдэл	Тайлбар	Орлого нэмэгдүүлэх санал /40.0 хувь/
			Эхлэх огноо	Дуусах огноо					
1	Цагдаагийн газар	ЗЦТ, нийтийн хэв журам	2017.07.01	2022.12.31	-	-	224,165.0	“Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт” нийцлийн аудитаар аймгийн Цагдаагийн газар, Татварын хэлтэст эрх бүхий албан тушаалтны ногдуулсан торгуулийн орлогыг бүрэн төвлөрүүлэх талаар нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж ажиллах зөвлөмж өгсөн.	89,666.0
2	Татварын газар	Татварын хяналт шалгалт	2023.01.01	2023.12.31	349,840.0	302,960.0	46,880.0		18,752.0
3	Татварын газар	Татварын хяналт шалгалт	2024.01.01	2024.12.31	218,095.0	128,155.0	89,940.0		35,976.0
4	Цагдаагийн газар	ЗЦТ, нийтийн хэв журам	2023.01.01	2023.12.31	812,090.0	746,200.0	65,890.0		26,356.0
5	Цагдаагийн газар	ЗЦТ, нийтийн хэв журам	2024.01.01	2024.12.31	926,980.0	815,080.0	111,900.0		44,760.0
6	Цагдаагийн газар	ЗЦТ	2025.01.01	2025.11.20	<del>407,100.0</del>	254,670.0	152,430.0		60,972.0
<b>Нийт</b>							<b>691,205.0</b>		<b>276,482.0</b>

2024.12.31  
 2025.11.20  
 2025.11.20  
 2025.11.20  
 2025.11.20

## Төсөвт байгууллагын өөрийн орлогыг нэмэгдүүлэх санал

мянган төгрөг

№	Байгууллага	Орлого нэмэгдүүлэх санал	Эх үүсвэр
1	Баян-Уул сумын ЗДТГ	6,200.0	Авто худаг
2	Бигэр сумын ЗДТГ	5,500.0	Авто худаг
3	Бугат сумын ЗДТГ	4,200.0	Буудал, хогны машин, Төрийн банк, Хаан банк
4	Дарив сумын ЗДТГ	600.0	Хогны машин
5	Жаргалан сумын ЗДТГ	600.0	Буудал
6	Тайшир сумын ЗДТГ	1,200.0	Буудлын орлого
7	Тонхил сумын ЗДТГ	1,200.0	Халуун ус
		1,200.0	Фитнес
		1,450.0	Буудал
8	Төгрөг сумын ЗДТГ	16,000.0	Авто худаг, буудал
9	Чандмань сумын ЗДТГ	8,650.0	ЗДТГ-ын өрөө, усны төлбөр
10	Шарга сумын ЗДТГ	1,200.0	Буудал түрээс, гуанз
11	Есенбулаг сумын ЗДТГ	1,000.0	Самбар түрээс, бусад
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>49,000.0</b>	

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

8217144139  
ДЮА0060 0018301

**Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн аймгийн ИТХ-ын 2025 оны 41 дүгээр тогтоолоор баталсан "Аймгийн хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөө"-нд тусгаагүй ажлын жагсаалт**

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Шинэ, шилжих	Төсөл арга хэмжээний ангилал	Хугацаа /оноор/		Төсөвт өртөг
				Эхлэх	Дуусах	
1	Баян-Уул сумын бага оврын цэвэрлэх байгууламжийн угсралт, суурилуулалт, зүгшрүүлэлт, тохируулгын ажил	шилжих	Барилга байгууламж	2024	2026	543,037.7
2	Бигэр сумын сургууль, цэцэрлэг, спорт заалны барилгыг дулаан хангамжид холбох ажил	шилжих	Барилга байгууламж	2024	2026	209,000.5
3	Есөнбулаг сум Алтай хотын нутаг дэвсгэрийн телехяналтын систем шинэчлэх, шинээр суурилуулах ажил	шилжих	Тоног төхөөрөмж	2025	2026	200,000.0
4	ЭМГ-с нэгдсэн эмнэлэг чиглэлийн цэвэр усны шугам солих ажил	шинэ	Барилга байгууламж	2026	2026	181,192.1
5	Халиун сумын цэвэрлэх байгууламжийг гадна цахилгаан хангамжид холбох ажлын үлдэгдэл санхүүжилт	шинэ	Барилга байгууламж	2026	2026	50,000.0
6	Жангар нийтийн номын сангийн засварын ажил	шилжих	Их засвар	2025	2026	491,148.3
7	Хөгжил хорооллын дулааны эх үүсвэрт холболт хийх	шилжих	Барилга байгууламж	2025	2026	499,813.8
8	Хөхморьт сумд наадмын талбай байгуулах	шилжих	Барилга байгууламж	2024	2025	180,000.0
9	Дотуур байрны барилгын дотор заслын ажил	шилжих	Барилга байгууламж	2026	2026	1,119,084.4
10	Жаргалан-Алтай ӨЭМТ-н өргөтгөлийн ажил	шинэ	Барилга байгууламж	2026	2026	555,268.9
11	Хуучин насос станцаас нарлаг төвийн урд тал хүртэлх цэвэр усны шугамыг хэсэгчлэн солих ажил	шинэ	Барилга байгууламж	2026	2027	612,079.5
12	Есөнбулаг сумын ариутгах татуургын 300мм голчтой шугам сүлжээг хэсэгчлэн солих ажил	шинэ	Барилга байгууламж	2026	2027	474,039.0
13	Төрөх эмнэлгийн засварын ажил	шинэ	Их засвар	2026	2027	1,139,677.1
14	Дарив сумд ундны усны худагт шүүлтүүр тавих	шинэ	Барилга байгууламж	2026	2026	35,000.0
15	Шарга сумын Хүүхдийн цэцэрлэгт худаг гаргах ажил	шинэ	Барилга байгууламж	2026	2026	35,000.0
16	Дарви сумын нэгдсэн халаалт, цэвэр, бохир усны шугамын зураг төсөв боловсруулах	шилжих	ТЭЗҮ	2024	2025	33,000.0
17	Марал-Алтай ӨЭМТ-н өргөтгөлийн барилгын ажлын зураг төсөв боловсруулах ажил	шинэ	ТЭЗҮ	2026	2026	19,900.0
18	Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцын 2 дугаар хэлхээний өөрчлөлтийн зураг төсөл боловсруулах ажил	шинэ	ТЭЗҮ	2026	2026	19,990.0
19	Ашиглалтын хугацаа дууссан 11,16-р байрнуудын дахин төлөвлөлтийн зураг төсөв хийлгэх ажил	шинэ	ТЭЗҮ	2026	2026	19,900.0
20	Аюулгүйн тойргоос Минж зочид буудал хүртэлх гудамж дахин төлөвлөлтөд хийх, барилгажилтын төсөл боловсруулах	шинэ	Барилга байгууламж	2026	2026	150,000.0
21	Сүүний үйлдвэрийн тоног, төхөөрөмж нийлүүлэх ажил	шинэ	Тоног төхөөрөмж	2026	2026	99,387.0
<b>Нийт</b>						<b>6,666,518.2</b>

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

8217144139  
ДЮА00060 0018301

## ӨМНӨХ ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

мянган төгрөг

№	Зөвлөмжийн заалт	Хэрэгжилт	Мөнгөн дүн	Тайлбар	Биелэлтийн хувь
1	Сумдын малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөлтийг тооцоход 2022 онд 325.2 сая төгрөг дутуу төлөвлөж, гүйцэтгэлээр 530.7 сая төгрөгийн орлого дутуу төвлөрсөн байна.	Сумдын малын тоо толгойн албан татварын төлөвлөөгүй байна.		Хэрэгжээгүй	0.0%
2	Бигэр, Бугат, Дэлгэр, Шарга сумдын ИТХ-аас бүх малын тоо толгойн албан татварын тоо хэмжээг нийтээр 0 төгрөг байхаар баталсан нь жууль тогтоомжтой нийцэхгүй байна.	Шинэчилсэн байна.		Хэрэгжсэн	100.0%
3	Аймгийн ИТХ-ын тогтоолоор өмч хувьчлалын орлогын төлөвлөгөөнд 7 барилга, 10 автомашиныг хувьчлахаар баталсан боловч хөрөнгийн доод үнийг батлаагүйгээс орлого орох боломжоо алдсан байна.	Шинэчилсэн байна.		Хэрэгжсэн	100.0%
4	Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 67 дугаар тогтоолын дагуу Баян-Уул сумын Соёлын төвийн хуучин барилгыг доод үнийг бууруулахгүйгээр дуудлага худалдааг зохион байгуулбал 35,325.3 мянган төгрөгийн орлого орох боломжтой байна.	Хэрэгжсэн байна.		Хэрэгжсэн	100.0%
5	Төрийн бус байгууллагын урсгал үйл ажиллагааны зардалд 279.1 сая төгрөгийн дэмжлэг олгохоор төсөвлөсөн нь аймгийн ИТХ-ын тогтоол, шийдвэргүй, гэрээ байгуулаагүй, Сангийн яаманд хянуулаагүй байна.	Хэрэгжээгүй	279,100.0	Хэрэгжээгүй	0.0%
6	Байгууллагын саналд үндэслээгүй урсгал засварын зардалд аймгийн ИТХ-д 50.0 сая төгрөг, ЗДТГ-т 180.0 сая төгрөгийг төлөвлөсөн нь зураг төсөв, бодит тооцоо судалгаагүй байна.	Хэрэгжсэн байна.	230,000.0	Хэрэгжсэн	100.0%
7	Аймгийн ОНХС-гаас хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 2,933.7 сая төгрөгийн 15 төсөл арга хэмжээ иргэдийн санал аваагүй нь сангийн журамд нийцэхгүй байна.	Хэрэгжсэн байна.		Хэрэгжсэн	100.0%
8	Аймгийн ОНХС-гаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг нийтэд нээлттэй хэлэлцүүлээгүй, Засаг даргын зөвлөлийн хурлаар төсөл арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг 11 сард хугацаа хоцроож хэлэлцүүлсэн байна.	Хэрэгжээгүй		Хэрэгжээгүй	0.0%
9	Аймгийн ОНХС-гаас хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 1,149.0 сая төгрөгийн өртөгтэй 6 төсөл арга хэмжээ нь зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлгүй, 3,394.7 сая төгрөгийн 17 төсөл арга хэмжээ хэрэгжсэний дараах өмчлөлтэй холбоотой асуудал, хөрөнгийн ашиглалтын урсгал зардлын тооцоог гаргуулаагүй байна.	Хэрэгжээгүй		Хэрэгжээгүй	0.0%
10	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн "Солонго дулааны станц" ААТҮГ-т эко хашаа шинээр барьж байгуулах ажил" төсөл арга хэмжээ нь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл тусгагдаагүй, нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтыг өгөөж, цаашид гарах урсгал зардлын тооцоогүй байна.	Хэрэгжээгүй		Хэрэгжээгүй	0.0%
11	Авто замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй 484.4 сая төгрөгийн өртөгтэй "Есөнбулаг сумын авто зогсоолуудыг өргөтгөх, шинэчлэл хийх ажил" төсөл арга хэмжээг шинээр хийхээр төлөвлөсөн байна.	Хэрэгжсэн байна.		Хэрэгжсэн	100.0%
12	Төсвийн төслийг хууль тогтоомжид заасан зарчим, шаардлагын дагуу боловсруулах үйл ажиллагаа хангалтгүй байна.	Хэрэгжих шатандаа		Хэрэгжих шатандаа	50.0%
<b>Биелэлтийн хувь</b>			<b>509,100.0</b>		<b>54%</b>

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

8217144133  
ДЮЛААН



Говь-Алтай айман дахь Төрийн аудитын газар  
/Есөнбулаг сум Баянхайрхан баг/



[www.audit.mn](http://www.audit.mn)



70483143



70484055